

Түүх 3 : Каин ба Абел

Библийн эшлэл
[Эхлэл 4:7]

Хэрэв чи сайныг үйлдвэл тэргүүнээ өргөх биш үү?
Хэрэв чи сайныг хийхгүй бол гэм нүгэл үүдэн дээр чинь гэтэн,
нүгэл хилэнц чамайг хүсэх болно. Гэвч чи түүнийг дийлэх ёстой.

Бурханы анхны бүтээл болох Адам, Ева хоёр нь хоёр хүүтэй болов.

Ахыг нь Каин, дүүг нь Абел гэдэг байв. Хоёр хүү нь өсөж том болжээ.

Каин нь тариачин болов. Дүү Абел нь хоньчин болов.

Нэгэн өдөр, дүү Абел нь хонин сүргийнхээ хамгийн анхны төл ба өөх тосоор Бурханд тахил өргөв.

Ах Каин нь ургацаасаа Бурханд өргөв. Гэтэл Бурхан Абелийн тахилыг хүлээн авч Каины тахилыг хүлээж авсангүй.

Каин маш их уурлан, дүү Абелаа үзэн яджээ.

Бурханд гомдсон гомдол, дүүдээ атаархсан атаархал бүх зүрх сэтгэлийг нь эзэмдсэн байлаа.

Нэг өдөр юу тохиолдох нь энэ вэ? Абел ерөөсөө харагдахгүй байв.

Бурхан Каинд хандаж: “Каин аа, Абел хаана байна вэ?”


Каин хариулав: “Бурхан минь! Абел хаана байгааг би яаж мэдэх вэ? Би дүүгийнхээ харгалзагч юм үү?” гэв.

Бурхан болсон бүх явдлыг мэдэж байсан бөгөөд. Каин дүү Абелийг хөнөөсөн гэдгийг ч Бурхан мэдэж байв.

Бурхан бүх зүйлийг мэдээд, Каинаас асуусан боловч Каин Бурханыг хуурах гэж оролдов.

Бурхан Каиныг шийтгэв. Хэдий Каин гэмт хэрэгтэн боловч Бурхан түүнийг өрөвдөн хэн ч Каиныг алахгүй гэж амлажээ.





- Дараах библийн эшлэлийг дээр нь дагаж бичээд цээжлээрэй. (Эхлэл 4:7)

Нүгэл хилэнц чамайг хүсэх болно. Гэвч чи түүнийг дийлэх ёстой.



Бүтээлч байцгаая 2. Өргөлүүдийг хайчилж аваад тохирох газарт наана уу.

Каин ←



→ Абел



